



2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2025 ОН

АГУУЛГА

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

1.1. Түүхэн замнал.....	5
1.2. Компанийн үйл ажиллагаа.....	6
1.3. Компанийн бүтэц, зохион байгуулалт.....	7
1.4. Төлөөлөн удирдах зөвлөл.....	7-8

ХОЁР. ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ.....8

ГУРАВ. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

3.1. Захиргаа удирдлагын хэлтсийн үндсэн чиг үүрэг.....	9-10
3.2. Компанийн бүтэц, орон тоо, ажилчдын судалгаа	
3.2.1. Хүний нөөцийн бүтэц, бүрэлдэхүүн.....	10-12
3.2.2. Хүний нөөцийн бодлогын ажлын хүрээнд.....	12-13
3.3. Хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилт	
3.3.1. Архив, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн үйл ажиллаганы хүрээнд.....	13-15
3.3.2. Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн хүрээнд.....	15-16
3.3.3. Өргөдөл гомдол хүсэлтийн шийдвэрлэлтийн хүрээнд.....	16-17
3.3.4. Ажилтан албан хаагчийн нийгмийн асуудлын хүрээнд.....	17-20
3.3.5. Ажилтнуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний ажлын хүрээнд.....	20-22
3.3.6. Ахмадын бүртгэл.....	22
3.4. Гэрээ, хууль, шүүхийн ажлын хэрэгжилт	
3.4.1. Гэрээний бүртгэл.....	23-24
3.4.2. Шүүхийн маргаантай хэргийн шийдвэрлэлт.....	24-25
3.5. Мэдээллийн технологи, дотоод сүлжээний ажлууд	
3.5.1. Интернет /шинэчлэл, хамгаалалт/.....	25
3.5.2. Сервер /шинэчлэл, засвар/.....	25-27
3.5.3. Суурин утас.....	27
3.5.4. Хурлын заал.....	28

ДӨРӨВ. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

4.1. Хэлтсүүдийн орлого, зарлага.....	28-30
4.2. Улсын төсөвт татвар хураамж төвлөрүүлсэн байдал.....	31
4.3. Авлага, өглөг.....	31-33

ТАВ. ЗАХИАЛАГЧ ТЕХНИК ХЯНАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД


5.1. Төсөл хөтөлбөр хэрэгжих шат.....	33-37
---------------------------------------	-------

5.2. Төсөл хөтөлбөрийн барилга угсралтын ажлын явц.....	37-49
5.3. Албан томилолт.....	50
5.4. Зохиогчийн хяналтын гэрээ.....	50-54
5.5. Барилга угсралтын ажлын үндсэн хөрөнгө.....	55
5.6. 2024 оны орлого, зарлага.....	55
ЗУРГАА. ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД	
6.1. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд.....	56
6.2. 2024 оны зорилтот түвшингийн төсөл.....	56-57
6.3. 2024 оны үйл ажиллагааны орлого, зардал.....	57-62
ДОЛОО. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХҮРЭЭНД	
7.1. Сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжийн техникийн хяналт.....	62-68
7.2. Түгээх сүлжээнд холбогдон ажиллаж буй хэрэглэгчийн Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн мэдээлэл.....	68-69
7.3. Сэргээгдэх эрчим хүчний техник эдийн засгийн үндэслэл, судалгаа шинжилгээний ажил.....	69-71
НАЙМ. ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД	
8.1. Туршилт, шинжилгээ баталгаажуулалтын ажил.....	72
8.2. 2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	72-73
8.3. Томилолт.....	73
8.4. Багаж, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт болон худалдан авалт.....	73
ЕС. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД	
9.1. Тусгай зөвшөөрлийн хүсэлт, ангилал.....	74
9.2. 2024 онд олгогдсон Тусгай зөвшөөрлийн үнэ төвлөрүүлсэн байдал.....	75
9.3. Тусгай зөвшөөрлийн мэдээллийн системд гүйцэтгэсэн ажил.....	76
9.4. Тусгай зөвшөөрлийн үнэт цаас зарцуулалт.....	76
9.5. Авлага барагдуулах ажлын хүрээнд.....	77
9.6. Тусгай зөвшөөрлийн баримт бичгийг магадлан шалгах ажлын хүрээнд	77
9.7. Техникийн нөхцөл.....	78-79
АРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН АТТЕСТАТЧИЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД	
10.1. Сургалтын үйл ажиллагаа.....	81-88
10.2. ЭХС-ын хууль дүрэм, журам, эрх зүйн орчны сургалт/танхим, цахим/.....	88-91
10.3. Хөлсөөр ажиллах гэрээт, зөвлөх багш нар оролцсон сургалт.....	91-92

10.4. Томилолт.....	92-93
АРВАН НЭГ. АЖ АХУЙН АЛБА	
11.1. Худалдан авах ажиллагааны хүрээнд.....	94-97
11.2. Хэвлэх цех.....	97
11.3. Хэвлэх цехийн орлогын задаргаа, гүйцэтгэл, ажлын үзүүлэлт.....	98-100
11.4. Үйлчилгээний хэсгийн үйл ажиллагааны хүрээнд.....	100-105
АРВАН ХОЁР. ДҮГНЭЛТ.....	105-106

1.1. ТҮҮХЭН ЗАМНАЛ

Зураг-1 Түүхэн замнал




Зураг-2 Эрчим хүчний үндэсний төвийн байр

Компанийн байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байрны өргөтгөл

Утас: 976-77116010, **Факс:** 77116030 **И-Мэйл хаяг:** info@nec.mn

1.2. КОМПАНИ НЬ ҮНДСЭН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛНА.




“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийг барих ажлын зураг, төсөвт магадлал хийх, шүүмж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, салбарын сургалтын хөтөлбөр, мэргэшлийн зэргийн аттестатчиллыг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, дулаанжуулалтын болон цахилгаан тоноглолд хяналт шинжилгээ хийх, Эрчим хүчний шинэ эх үүсвэр шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авах, баримт бичгийг магадлан шалгах, урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах, гэрээ байгуулах, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох сэргээгдэх эрчим хүчний зураг төсөл боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээртэй холбоотой судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, засвар үйлчилгээ үзүүлэх, нарны зайн үйлдвэрлэл, угсралт, тохируулга хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий компани юм.

1.3. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу бүтэц, орон тооны бүрэлдэхүүнтэйгээр ажилласан бөгөөд 2024 оны 11 сарын 25-ны өдрийн А/34 тоот тушаалаар бүтэц, орон тоог 94 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан.

Зураг-3 Бүтэц



1.4. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Зураг-4 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц



Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант онд 11 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн хязгаарлалттай болон тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 20 тогтоолыг хэлэлцэн баталсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 2 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, 2024 оны зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, батлуулан ажилласан.

ХОЁР. ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулах, хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлэхэд хяналт тавьж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх бүтээн байгуулалтад оролцох, салбарын инновацийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

“Алсын хараа 2050” урт хугацааны төлөвлөлтийн бодлого, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь салбарын өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн ажиллаж байна.

Алсын хараа



Төрийн бодлогын хүрээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагад чанартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлсэн үндэсний хэмжээний мэргэшсэн байгууллага болно.

Эрхэм зорилго



Эрчим хүчний салбарт технологийн шинэчлэлтийг цаг алдалгүй нэвтрүүлж, техникийн хяналтыг норм стандартын дагуу хэрэгжүүлэн, чиг үүргийн биелэлтийг хангуулж, хөгжлийг түүчээлэгч байгууллага болно.

Эрхэмлэх үнэт зүйлс

Бидний эрхэмлэх үнэт зүйлсүүд:



- Мэдлэгт суурилсан чадвартай байх
- Хууль, Ёс зүйг дээдэлдэг байх
- Шуурхай, Хариуцлагатай, ил тод байх
- Үр ашиг, хэмнэлттэй байх
- Байгаль орчинд ээлтэй байх

3.1. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Компанийн үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, компанийн үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийг зөв байршуулах, тэдгээрийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдүүлэх, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ зорилтын хүрээнд доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, холбогдох бусад эрх зүйн акт, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг компанийн хэмжээнд дагаж мөрдүүлэх,
- Компанийн хүний нөөцийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих ерөнхий удирдлагаар хангах
- Удирдлагын шийдвэр, гүйцэтгэлийн нэгдлийг хангах, хяналт тавих, энэ хүрээнд компанийн гүйцэтгэх захирлын батлан гаргаж буй тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулах,
- Компанийн дотоод журмыг сахин биелүүлэх, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах, хэлтсийн ажилтнуудын үр дүнг сар, улирал, жилээр тооцох, ажилтнуудын ажилд үнэлэлт дүгнэлт өгөх;
- Компанийн ажилчдын орон тоо, цалин хөлсний асуудал хариуцаж, урамшууллын механизмыг оновчтой үр ашигтай хэлбэрээр боловсруулан хэрэгжүүлж, хяналт тавих;
- Компанийн байгуулсан гэрээ, хэлэлцээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийн хангуулах, хяналт тавих;
- Компанийн ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх, компанийн нэр дээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, хариуг өгөх;
- Хэлтэс, нэгжийн календарьчилсан төлөвлөгөөг баталгаажуулах, 7 хоног, сар, улирал болон жилийн ажлын тайланг нэгтгэн гаргах, хамгаалуулах,
- Бүтэц, нэгжийн үүрэг даалгаврын биелэлт, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг нэгтгэж, холбогдох газарт хүргүүлэхэд анхаарч ажиллах,
- ЭХЯ болон ТӨБЗГ, компанийн ТУЗ, бусад газраас ирүүлсэн албан бичигтэй танилцаж, шаардлагатай тохиолдолд хариу бичиг төлөвлөж, төсөл, санал боловсруулан тус хэлтсийн даргаар хянуулан, гүйцэтгэх захиралд танилцуулж баталгаажуулах зэрэг үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.
- Төвийн өндөр настан ахмадуудад нийгмийн халамж дэмжлэг үзүүлэх асуудлыг салбарын ахмадын хороотой хамтран төлөвлөж хэрэгжүүлэх;
- Мэдээллийн шинэ техник, технологи нэвтрүүлэх бодлогыг дэмжих, хэрэгжилтийг хангах;

- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагуудтай харилцаа тогтоох, хамран ажиллах талаар санал боловсруулах, гэрээ байгуулах;

3.2. КОМПАНИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО, АЖИЛЧДЫН СУДАЛГАА

3.2.1. Хүний нөөцийн бүтэц, бүрэлдэхүүн

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн бүтэц, зохион байгуулалтыг баталж, орон тооны дээд хязгаарыг 94 байхаар тогтоосон.

Шинээр ажилд томилогдсон ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулж, ажлын байр, хөдөлмөрийн дотоод журмыг танилцуулан ажилд нь чиглүүлэх, эрхэлсэн ажлын чиглэлээр ирсэн албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авч цаг тухай бүр шийдвэрлүүлж ажилласан.

Захиргаа удирдлагын хэлтсээс ажлын байрны албан тушаалд тавигдах шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, ажлын чиг үүргийн онцлогт нийцүүлэн ажлын давхардлыг арилган ажилласан. Үүнд:


❖ 2024 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар хүний нөөцийн урсгал, оролт, гаралтын хөдөлгөөнийг шинжилбэл:

Хүснэгт-1

Хугацаа	Ажиллагсдын тоо
2022 оны сүүл шинэ бүтэц	94
Удирдлага, хэлтэс нэгжийн бүрэлдэхүүнд-79	- Гүйцэтгэх захирал -1 - Ерөнхий инженер -1 - Аудитор -1 - Захиргаа, удирдлагын хэлтэс - 7 - Санхүү, эдийн засгийн хэлтэс - 5 - Захиалагч, техник хяналтын хэлтэс -15 - Зураг төсөл, магадлалын хэлтэс -7 - Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс - 6 - Эрчим хүчний салбарын нэгдсэн лаборатори - 9 - Сургалт үйлдвэрлэлийн төв -13 - Тусгай зөвшөөрлийн алба - 3 - Аж, ахуйн алба - 11 тус тус идэвхтэй ажиллаж байна
2024 оны 12-р сарын 31-ны байдлаар	Үүнээс: Идэвхтэй ажиллаж байгаа 79 Хүүхэд асрах чөлөөтэй-6 Урт хугацааны чөлөөтэй-1
Оролт, гаралтын байдал	Оролт: 8 Гаралт: 8 - /Өөрийн хүсэлтээр/ Тэтгэвэр -2
Хүний нөөцийн тогтворжилт	8.5 % буюу үзүүлэлтэй гарч байна.

Жич: Идэвхитэй ажиллаж байгаа 79. Хүүхэд асрах чөлөөтэй - 6, гэрээтээр ажиллаж байгаа-3, сургалтын чөлөөтэй-1,

График-1



НИЙТ АЖИЛТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН:

График-2


- Дээд: 71 ажилтан
- Тусгай дунд: 1 ажилтан
- Бүрэн дунд: 3 ажилтан
- Бүрэн бус дунд: 4 ажилтан



САЛБАРТ ТОГТВОРТОЙ АЖИЛЛАСАН ЖИЛ:

График-3


- 0-5 жил: 23 ажилтан
- 6-10 жил: 26 ажилтан
- 11 - 20 жил: 20 ажилтан
- 21-ээс дээш жил: 10 ажилтан



НАСНЫ АНГИЛАЛ:

График-4


- 20 - 35 нас: 30 ажилтан
- 36 - 45 нас: 30 ажилтан
- 46 - 55 нас: 19 ажилтан
- 56-аас дээш нас: 9 ажилтан



АЖИЛЛАГСДЫГ АЛБАН ТУШААЛААР АНГИЛБАЛ:

- Удирдах ажилтан	12 ажилтан
- ИТА	44 ажилтан
- Мэргэжилтэн	12 ажилтан
- Албан хаагчид	20 ажилтан


График-5



ХҮЙСИЙН ХАРЬЦАА:

- Эр - 49 /56%/
- Эм - 39 /44%/

График-6



Компанийн батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан хүний нөөц, хөдөлмөрийн харилцааг хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж баталгаажуулан ажилласан. Компанийн ажиллагсдын оролт гаралтын хөдөлгөөн, ажлын цаг ашиглалтын тооцоог тухай бүр гаргаж, ажиллагсдын мэдээллийг тухай бүр шинэчлэн бүрдүүлэн ажиллаж байна.

3.2.2. Хүний нөөцийн бодлогын ажлын хүрээнд

Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж нийтийн албанд танилын хүрээ, зүй бус нөлөөллөөр хуульд заасан шаардлага хангаагүй албан хаагчдыг ажилд аваагүй бөгөөд одоогоор чиг үүргийн дагуу 79 ажилтан, албан хаагчтай ажиллаж, 3 орон тоог хавсран гүйцэтгүүлэн ажиллуулж байна.

Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайлалыг хангах, хүний нөөцийг зөв байршуулах, тэдгээрийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хүний нөөцийн стратеги, төлөвлөгөө, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, үр нөлөөтэй явуулах зорилгоор "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг нэгдүгээр хавсралтаар, холбогдох "Ажилтан сонгон шалгаруулах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Хүний нөөцийн хувийн хэргийн бүрдүүлэлт, дүн бүртгэл судалгаа хийх журам"-ыг гуравдугаар хавсралтаар, "Сургалтын журам"-ыг дөрөвдүгээр хавсралтын дагуу тус тус шинэчлэн 2023.05.04-ний өдрийн А/29 тоот тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хэрэгжилт

Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлтэс байгууллагын болон нэгжийн хаягийг монгол бичгээр хөрвүүлэн хаягжуулж ажилласан бөгөөд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2024.04.26-ны 165 дугаар тогтоолтой танилцаж, нийт ажилчдын дунд монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгааг авч, ажилтнуудын монгол бичгийн анхан шатны боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Тайланг тухай бүр өгч ажилласан.

Зураг-5 Монгол бичгийн хаягжилт



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлс, урамшууллын дүнг албан ёсны сайтад нээлттэй, ил тод байршуулан Авлигатай тэмцэх үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолтой тогтоолтой танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЗУХ-ийн дарга Т.Солонго, ахлах мэргэжилтэн Н.Оюундэлгэр нар Энэтхэг багштай 3 өдрийн “ISO 37001:2016 Anti bribery management system training” сургалтад хамрагдсан.

MNS ISO 37001:2017 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, стандартын талаар мэдлэг олгох сургалтад СЭХХ-ийн ахлах мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. ISO37001:2016 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс зөвлөн туслах үйлчилгээний үнийн саналыг авч хамтарч ажиллахаар харилцан тохиролцсон.

3.3. ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ТУШААЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

3.3.1. Архив, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн үйл ажиллагааны хүрээнд

Компанийн албан хэрэг хөтлөлтийн ажлыг хөнгөн шуурхай, тасралтгүй, үр ашигтай байлгах түүнчлэн албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зохион бүрдүүлэх, баримт бичгийг найдвартай нөхцөлд хадгалах зорилготой ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь МУ-ын Архивын тухай хууль, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартын эмхэтгэл болон ЭХХТ-ийн албан хэрэг хөтлөлтийн журмыг тус тус удирдлага болгон ажиллаж байна.

Байгууллагын баримт бичгийн эргэлтийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж, удирдлагын үйл ажиллагаанд шинэ нэр төрлийн баримт бичиг үүсч хөтлөгдөх хандлагатай бөгөөд баримт бичиг боловсруулах, мэдээлэл солилцох үйл ажиллагааны хэлбэр улам

боловсронгуй болж байгаатай холбогдуулан албан хэрэг хөтлөлтийн зохион байгуулалтыг сайжруулж, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг оновчтой болгох үүднээс байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмыг 2024 онд шинэчлэн баталгаажуулан ажилласан.


Цаашид албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлж, баримт бичигтэй ажиллах ажлын бүх хүрээг хамрах зайлшгүй шаардлага байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд АЕГ-ын Архив, АХХХУЕБ 02 дугаартай удирдамж хүлээн авч, мөрдөж ажиллаж байна.

Хүснэгт-2 Баримт бичгийн эргэлтийн мэдээ

УДИРДЛАГА	ЗУХ	СЭЗХ	ЗТХХ	ТЗА	ЗТМХ	СҮТ	НЛ	СЭХҮТ
• Ирсэн-16 • Явсан-6	• Ирсэн-74 • Явсан-98	• Ирсэн-121 • Явсан-84	• Ирсэн-652 • Явсан-593	• Ирсэн-38 • Явсан-60	• Ирсэн-845 • Явсан-33	• Ирсэн-4 • Явсан-47	• Ирсэн-104 • Явсан-24	• Ирсэн-86 • Явсан-82

График-7 Баримт бичгийн эргэлтийн мэдээ



Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төлөвлөгөөтэй танилцаж, Архивын мэргэжилтэн С.Уянгын мэдээллийг хавсралтын маягтын дагуу гарган өгч мэргэшүүлэх сургалтад хамруулж ажилласан.

Албан хэрэг хөтлөлт, албан баримт бичгийн эргэлтийн мэдээг тогтмол гарган ажилладаг . Үүнд:

- Гүйцэтгэх захирлын баталсан нийт **139 ТУШААЛЫГ** төслийн дагуу хэвлэмэл хуудсанд буулган ахлах мэргэжилтэнд хүлээлгэн өгч ажилласан.
- Байгууллагад **ИРСЭН 1941** албан бичиг тус бүрийн эх буюу нүүр хуудсыг сканерт оруулан цахим архив үүсгэн бичиг хэргийн программд бүртгэн холбож, инженер, мэргэжилтэн нарт шаардлагатай тохиолдолд гарган өгч ажилласан,
- Байгууллагаас **ЯВУУЛСАН 1105** дугаар бүхий албан бичгийг холбогдох инженер, мэргэжилтнүүдийн боловсруулсан, удирдлагын гарын үсгээр баталгаажуулсан

- төслийг цаасаар болон онлайн хэлбэрээр хүлээн авч, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангуулан, хэвлэмэл хуудсанд буулгаж, удирдлагын гарын үсэг зуруулан, дугаар олгон баталгаажуулж, хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх буюу шуудангаар явуулах албан бичгийг дэвтэр хөтөлж, илгээж ажилласан болно.
- Байгууллагад гаднаас ирсэн **өргөдөл, гомдол, хүсэлтийн -1** хүлээн авч бүртгэн удирдлагад танилцуулж, холбогдох хэлтэс нэгжүүдэд шилжүүлсэн. Дотооддоо гарсан **29 ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ** картлан бүртгэж, ЗУХ-т шилжүүлэн ажилласан.
 - Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн **ТАЙЛАН 7** хоног бүр гарган өгч ажилласан.
 - Байгууллагатай холбоотой албан бичгийн мэдээллийг өгөх, **АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ**, хугацаа хэтэрсэн бичгийн талаарх мэдээг тухай бүр хэлтэс нэгжийн удирдлагуудад танилцуулж ажилласан.
 - Бичиг хэрэгт төвлөрөн хадгалагдаж буй баримт бичгийг дараа оны эхэнд ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлэх, байгууллагын архивд шилжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.
 - Байгууллагын хэмжээнд шуудангаар 621 албан тоот явуулж, албан бичгийн бүртгэл хөтөлж тухай бүр илгээж ажиллаж байна.
 - Хуулбар үнэн тамга тэмдгийн бүртгэл хөтөлж гарын үсгээр баталгаажуулах ажиллах. (37 бүртгэл хийгдсэн)
 - Төвийн утасны жагсаалтыг тухай бүр шинэчлэн баталгаажуулсан.
 - Тайлангийн хугацаанд 26 тоот тодорхойлолтын төслийг боловсруулж, баталгаажуулж холбогдох банк санхүүгийн байгууллага болон Элчин сайдын яам бусад байгууллагуудад давхардсан тоогоор явуулсан.

3.3.2. Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн хүрээнд

Компанийн хэмжээнд 2024 онд бүтэц, орон тооны дээд хязгаар (94)-т нийцүүлэн ажилласан бөгөөд сул орон тоог хасч, хэвлэх цехийн гэрээт 3 ажилтныг үндсэн бүтцэд оруулахаар ТУЗ-д санал оруулж дэмжигдсэн тул 2024.11.25-ны өдрийн А/34 дугаартай тушаалаар албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлуулж, харьцангуй тогтвортой ажилласан.

Шинээр батлагдсан бүтцийн дагуу гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03 дугаартай тушаалаар ХАСХОМ гаргавал зохих нэрсийг баталсан. Улмаар шинээр томилогдсон 1 ажилтныг авлигатай тэмцэх газраас ХАСУМ хянуулж, ажлын байрны тодорхойлолтод нийцсэн 14 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд тайлагнан хянуулж ажилласан.

Компанийн батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан хүний нөөц, хөдөлмөрийн харилцааг хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан баталгаажуулж ажилласан. Үүнд: Нийт 139 тушаал боловсруулан батлуулснаас Б тушаал 103, А тушаал 36

- Нэмэгдэл, шагнал, урамшуулал - 30
- Дүрэм журам батлах тухай - 2
- Хавсран ажиллуулах-5
- Ээлжийн амралттай холбоотой -1
- Буцалтгүй тусламж, тэтгэмж, олговор олгох -6
- Хүүхэд асрах чөлөө олгох, сунгах -5
- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох -2
- Ажлаас чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох -10
- Ажилд авах, томилох, ажлын байрны шилжилт -15
- Бүтэц зохион байгуулалт -1
- Хариуцлага тооцох - 2
- Үргэлжлүүлэн ажиллуулах - 4

- Ажил хүлээлцүүлэх, ажлын хэсэг байгуулах -1
- Бусад – 4

3.3.3. Өргөдөл гомдол хүсэлтийн шийдвэрлэлтийн хүрээнд

2024 онд нийт 30 өргөдөл ирснээс-Гаднаас ирсэн өргөдлийн шийдвэрлэлт-1, Дотоод ажилчдаас гаргасан өргөдлийн шийдвэрлэлт-29 өргөдөл, хүсэлт ирсэн. Шийдвэрлэлтийн биелэлт 100 хувь. Үүнээс:

- Гаднаас ирсэн -1
- Мэргэжилийн зэргийн нэмэгдэл болон урамшуулал олгох -5
- Чөлөө хүсэх, сунгах – 5
- Ажлаас гарах, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох -8
- Ажилд орохыг хүссэн - 2
- Тэтгэмж хүссэн -3
- Сургалтад хамруулах, төлбөр шийдвэрлүүлэх -2
- Бусад -4 хүсэлт ирсэн байна.

Компанийн батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай холбоотой дараахь дүрэм журмыг шинээр боловсруулан баталгаажуулж ажилласан. Үүнд:

Хүснэгт-3 2024 онд батлагдсан дүрэм, журам

№	Батлагдсан огноо	Товч утга	Тайлбар
Шинэчлэн баталсан дүрэм, журам			
1	2024.01.10	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай	A/01
2	2024.02.15	Журам батлах, нууцын ажилтан томилох тухай Н.Оюундэлгэр	Б/15
3	2024.05.22	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам батлах тухай	A/17
4	2024.09.18	Сургалт үйлдвэрлэлийн төвийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	A/24
5	2024.10.22	Эд хөрөнгийн тооллого явуулах журам батлах тухай	A/31
6	2024.11.11	НББ-ийн бодлогын баримт бичиг мөрдөж ажиллах тухай	A/33

Компанийн ажиллагсдын оролт гаралтын хөдөлгөөн, ажлын цаг ашиглалтын тооцоог тухай бүр гаргаж, ажиллагсдын мэдээллийг шинэчлэн бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

Ажилтан, албан тушаалтныг ажлаас чөлөөлөх:

1. Тайлант хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн-10, үүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн-8, өндөр насны тэтгэвэрт гарахтай холбогдуулж ажлаас чөлөөлөгдсөн-2 байна.

Сахилгын шийтгэл ногдуулах:

2. Сахилгын зөрчил гаргасан 3 ажилтанд дахин зөрчил гаргахгүй байхыг сануулж, 1 сарын үндсэн цалингийн 20 хувиар бууруулж хариуцлага тооцсон.

Хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ:

3. Нийт ажилтан, албан хаагчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээний хугацааг 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн “хугацаагүй” байгуулсан.
4. 2024 онд сургалт үйлдвэрлэлийн төвөөс Эргэх механизм, дулааны оруулгын слесарь, өндөр даралт хаалт арматур, зуух турбины машинист засварчин, химийн аппартчин, санхүү эдийн засаг, хүний нөөц, хууль эрхзүй, харилцааны соёл, цагийн менежмент чиглэлээр цахилгаан дулааны нарийн мэргэшсэн зөвлөх мэргэшсэн инженер 30 гаруй гэрээт зөвлөх багш ажилласан бөгөөд нийт 2960 цаг буюу 30 гаруй төрлийн сургалт явуулахад оролцсон байна.
5. Гэрээт багш нар СҮТ-д 339,9 сая төгрөгийн орлого оруулсан бөгөөд гэрээт ажлын хөлсөнд 36,7 сая төгрөг зарцуулсан байна.
6. Тайланд хугацаанд ЗТМХ-ийн ажилд 62 хүнтэй экспертийн гэрээ хийж, 249,422,924.85 төгрөгийн цалинг олгосон.

3.3.4. Ажилтан албан хаагчийн нийгмийн асуудлын хүрээнд

Компанийн гүйцэтгэх захирлын эрх хэмжээг ТБОНӨТХ-с гадна Компанийн тухай хууль, компанийн дүрэм, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөлтэй Хөдөлмөрийн гэрээгээр тогтоосон бөгөөд энэ хүрээнд эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг биелүүлж ажиллахаас гадна өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал, компанийн 2023-2024 оны Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталгаажуулж ажиллаж байна.

Энэ хүрээнд ажилтан, албан тушаалтны нийгмийн асуудлыг Хамтын гэрээ, дотоод журмын хүрээнд хууль тогтоомжийн дагуу олгохоор заасан тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэгийг компанийн зүгээс өөрийн санхүүгийн чадамжинд тулгуурлан олгосон. Үүнд:

- Компанийн 2023-2024 онд байгуулсан Хамтын гэрээний хүрээнд 4 удаа тушаалаар ажилтан албан хаагчийн өөрөө болон түүний ар гэрт нийт 11,616,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус үзүүлж ажилласан.
- 2024 онд тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 2 ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож нэг удаагийн мөнгөн тэтгэмж нийт 43,857,000 төгрөгийг олгосон.
- Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан 2 ажилтанд 1,936,000 төгрөгийн урамшуулал олгосон.

Зураг-6 Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдах үе



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай хуулийг сурталчлах аян зохион байгуулж, энэ хүрээнд байгууллагын ажилчдын дунд байгаа 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгай кодоор бүртгэн ажиллаж байгаа бөгөөд ажилчдын хүүхдүүдийн дунд тусламж шаардлагатай байгаа 3 хүүхдэд 2024.10.17-ны Б/77 дугаартай тушаал 3,168,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож тэднийг дэмжиж ажиллаж байгаа бөгөөд тайланг ЭХЯ-нд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.
- Бага насны хүүхэдтэй эцэг, эхийг дэмжиж, ажиллах нөхцөлөөр хангах ажиллах ажлын хүрээнд байгууллагын 1 давхарын үүдний хажуу талын хоосон өрөөг 2024.05.20-ний өдөр хүүхдийн өрөөгөөр тохижуулж, нийт ажилчдад танилцуулж ажилласан.

Зураг-7 Хүүхдийн өрөөний шинэчлэлт, тохижуулалт



- Хүүхдийн эрхийн тухай хуулийн хүрээнд нийт ажилтнуудын 123 хүүхдэд гарын бэлэг өгч хүүхдүүдийн дунд “Аав, ээжийн мэргэжил” сэдэвт зургийн уралдааны зохион байгуулж түрүүлсэн хүүхдэд гарын бэлэг өгч, шагнасан. Мөн 2024.05.20-ний өдөр Бадамлянхуа” хүүхдийн асрамжийн газартай танилцан, хандив тусламжийн аян зохион байгуулсан зураг

Зураг-8 Хүүхдийн баяр



- Эрчим хүчний яамны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, 2024.11.06-ны өдөр Дундговь аймагт байгууллагаас 2024 онд 94 модыг хүлээн авч ажилласан.

Зураг-9 Дундговь аймаг ногоон зурвас байгуулаж ажил



- Эрчим хүчний үндэсний төвийн “NEC SPORT-2024” тэмцээнийг ҮЭХ-ны гишүүдтэй хамтран зохион байгуулж ажилласан.

Зураг-10 NEC SPORT-2024



Эрчим хүчний салбарт ХАБЭА-г хангах ажиллах тухай

ХАБЭА-н зардлыг өөрийн байгууллагын санхүүгийн чадамжтай уялдуулан төсөвлөн батлуулж ажилласан бөгөөд энэ талаар компанид ирсэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024.03.29-ний өдрийн 07/00-01/001-06 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийн талаарх тайлан мэдээллийг ХАБЭА-н инженер Ш.Ариунаа гарган Салбар хяналтын газарт хүргүүлэн ажилласан.

Зураг-11 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт



Гамшгаас хамгаалах хуульд зааснаар эрсдлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөмжийн дагуу ХАБЭА-н инженер хийсэн ажлын мэдээг ЭХЯ-нд хүргүүлэн ажилласан.

Мөн ажилчдын эрүүл орчинд ажиллаж хөдөлмөрлөх, цалин хөлс авах, нийгмийн хамгааллын ажлын хүрээнд: Эрүүл мэндийн үзлэгийг нийт ажилтнуудын дунд чанартай хийлгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, улмаар Сонгдо эмнэлгийг сонгон, үзлэгт 86 ажилтанг хамруулан Хамтын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэн ажилласан.

Компанийн нууцын талаар

Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу 2024.02.15-ны өдрийн А/03-01 дугаартай тушаалаар нууцын журам баталсан бөгөөд уг журмын нэгдүгээр хавсралтаар байгууллагын нууцад хамаарах баримт бичгийн төрлийн жагсаалт болон холбогдох эрх бүхий албан тушаалтнуудыг, хоёрдугаар хавсралтаар тэдгээр албан тушаалтнуудаас авах нууцын баталгааны маягт хуудсыг баталгаажуулан холбогдох ажилтнуудаас баталгааг авч ажилласан.

Тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээлэл гараагүй.

Зайлшгүй шаардлагатай үед нууц хадгалах гэрээг тухай бүр хийхээр төлөвлөн ажиллаж байна.

3.3.5. Ажилтнуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах

- ЭХС-ын хэмжээнд хийгдэж байгаа хүний нөөцийн бодлогын дагуу 2024 оны 10.27-11.03 өдрүүдэд GLOBAL HR FORUM-2024 ОУ-ын арга хэмжээнд 2 ажилтанг оролцуулахаар А/32 дугаартай тушаал гаргасан.

Зураг-12 GLOBAL HR FORUM-2024 ОУ-ын арга хэмжээ



- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2024.04.16-ны өдөр Эрчим хүчний шилжилт ба жендэрийн тэгш байдал уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.

Зураг-13 Эрчим хүчний шилжилт ба жендэрийн тэгш байдал уулзалт



- 2024.05.17-ны өдөр USAID-ын Эрчим хүчний засаглал хөтөлбөрөөс зохион байгуулагдсан "Монгол улсын цэвэр эрчим хүчний шилжилтээр эмэгтэйчүүдэд гарч ирэх боломж" сэдэвт чөлөөт хэлэлцүүлэгт оролцсон.

Зураг-14 "Монгол улсын цэвэр эрчим хүчний шилжилтээр эмэгтэйчүүдэд гарч ирэх боломж" сэдэвт чөлөөт хэлэлцүүлэг



- 2024.11.22-ны өдөр зохион байгуулсан Шинэ эрчим хүчний чуулганы хүрээнд Жендэрийн тэгш байдлыг сайжруулах цогц системийн хүрээнд эрэгтэйчүүдийг жендэрийн асуудалд оролцох оролцоог нэмэгдүүлэх талаар санал солилцох хэлэлцүүлэгт хамрагдсан.



3.3.6. Ахмадын бүртгэл

Ахмадын тухай хууль, ЭХС-ын 2023-2024 оны Хамтын хэлэлцээр, байгууллагын 2023-2024 оны Хамтын гэрээний хүрээнд Б/14, Б/69 дугаартай тушаалаар тус тус 173 сая төгрөгийн тэтгэмж өгсөн бөгөөд Эрчим хүчний яам, Ахмадын хороотой хамтран нийт 84 ахмадыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

Зураг-16 Цагаан сарын ахмадын хүлээн авалт



Ахмадын хорооны дарга Л.Балганыг ажлын өрөө, тасалгаа, ажиллах нөхцөл боломжоор ханган дэмжиж ажилласан.

ЭХЯ-наас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу дараах ахмадыг ЭХС-ын ахмадын

- ЭХЯ-с ирүүлсэн хүсэлтийн дагуу 2022 онд гарсан өндөр настан Мэнд-Очирын Лхамхүүг ахмадын бүртгэлд бүртгэн ажилласан.
- ЭХЯ-НЫ ТНБД-ын 2024.02.29-ны өдрийн Б/27 тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэрт тогтоолгосон Д.Оюуныг ахмадын харьяалалд бүртгэн ажилласан.

Жич: ЭХС-ын Хөдөлмөрийн баатрууд 5 хүнийг бүртгүүлэх саналыг Ахмадын хорооны даргад мэдэгдэн, судалгаа хийж, ажилласан бөгөөд тус салбарын аль байгууллагаас тэтгэвэрт гарсан болох нь тодорхойгүй шалтгаанаар бүртгэл хийгээгүй хойшлуулсан болно.


3.4. ГЭРЭЭ, ХУУЛЬ, ШҮҮХИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

3.4.1. Гэрээний бүртгэл

Хүснэгт-4 2024 онд байгуулагдсан нийт гэрээ

№	Байгуулагдсан гэрээний төрөл	Тоо
1	Техник хяналт, зохиогчийн хяналт хийх гэрээ	59
2	Худалдах, худалдан авах гэрээ	18
3	Ажил гүйцэтгэх болон бусад	60
4	Зураг төсөлд магадлал хийх гэрээ	751
5	Зураг төслийн баримт бичиг магадлал хийх иргэнтэй байгуулах гэрээ	11
6	Нэгдсэн лабораторийн туршилт тохируулгын ажил гүйцэтгэх гэрээ	183
7	Тусгай зөвшөөрөл эзэмших, эзэмшүүлэх гэрээ	202
8	Сэргээгдэх эрчим хүчний гэрээ	13
9	Сургалт үйлдвэрлэлийн төвийн гэрээ	42
	Нийт	1339

График-8 Гэрээний хэрэгжилтийн талаар



Төрийн өмчийг бусдад түрээслүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу ТӨБЗГ-ын гурвалсан гэрээ байгуулан ажилласан. Үүнд:

1. БГД гурвалжингийн гүүрний баруун талд байрлах ЭХҮТ-ийн эзэмшлийн 650м2 техник үйлчилгээний байрыг нэг жилийн хугацаатай “УБЦТС” ТӨХК-ийн трансформаторын цехэд ажлын байрны зориулалтаар түрээслүүлж жилийн орлогын 40 хувь болох нийт 31,200,000 төгрөг
2. ЭХҮТ-ийн байрны 1 давхрын 150м2 талбайг нэг жилийн хугацаатай иргэн Н.Цэнджаргалд Цайны газрын зориулалтаар түрээслүүлж жилийн орлогын 40 хувь болох нийт 7,200,000 төгрөг

3. ЭХҮТ-ийн хашаан дотор байрлах 60м² талбай бүхий автогражийг нэг жилийн хугацаатай ЭБУЦС-ын төслийн нэгжид автогражийн зориулалтаар түрээслүүлж жилийн орлогын 40 хувь болох нийт 3,456,000 төгрөгийг тус тус ТӨБЗГ-ын дансанд төлбөр төлөх хуваарийн дагуу төвлөрүүлсэн.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтыг удирдлага болгон “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 2024.09.06-ны өдрийн А/22 тоот тушаал шинэчлэн баталж үндсэн хөрөнгө ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, Эд хөрөнгийн тооллогын комиссыг 2024.04.09-ний өдрийн А/08 дугаартай тушаалаар, 2024.11.11-ний А/32 дугаартай тушаалаар тус тус байгуулан хагас болон бүтэн жилээр эд хөрөнгийн дотоодын тооллогыг явуулан ажилласан.

3.4.2. Шүүхийн маргаантай хэргийн шийдвэрлэлт

1.“Оасис Грийн” ХХК-иас НД, 5-р хороонд байрлах 33 га газрыг хамгаалж байсан бөгөөд зарим хэсгийг авах тухай шүүхэд нэхэмжлэл гаргасан иргэний хэрэгт:

ХУДИХАШШ-с ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу 2024.06.05-ны өдөр 1/424 тоот албан бичгээр Д.Пүрэвсүрэн, Н.Оюундэлгэр нарт итгэмжлэл хийлгэн шүүхийн нэхэмжлэлтэй танилцан хариу тайлбар өгч ажилласан бөгөөд нэхэмжлэгчтэй уулзаж гаргасан нэхэмжлэлийг шүүхээс буцаалган ажилласан.

2.Түмэн-Алт ХХК-с 355,714,568 төгрөг гаргуулах тухай тус төвийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт:

Шүүхийн 3 шатны шийдвэр гарсан хэдий ч өр төлөрийг барагдуулаагүйн улмаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт Лумаагийн Балганд итгэмжлэл хийж өгч, “Түмэн-алт” ХХК-с шүүхийн шийдвэрт заасан хөрөнгө, мөнгийг гаргуулахаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг эрчимжүүлэн хөрөнгийг битүүмжлүүлэн ажилласан бөгөөд “Түмэн-Алт” ХХК-с өр, төлбөрийг барагдуулахаар харилцан тохиролцож барьцааны болон авлага барагдуулах гэрээг тус тус хийж, улмаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт битүүмжээс чөлөөлөгдөх хүсэлтийг гаргаж өгч гэрээгээр дурдсан хугацаанд төлбөрийг төлж барьцааны хөрөнгийг буцаан авах тухай гэрээ хийж ажилласан.

3. Тус төвийн нэхэмжлэлтэй НӨАТ төлөгч эсэх талаарх захиргааны шүүхэд маргаан үүсгэсэн захиргааны хэрэгт:

Хан-Уул дүүргийн татварын хэлтэст 1.3 тэрбум төгрөгийг суутган тооцоолол хийж, 3,1 сая төгрөгийн торгууль 62,1 сая төгрөгийн алдангийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр төлж барагдуулсан.

Цаашид хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр гэрээт хуульч авч ажиллуулж байгаа бөгөөд ижил статустай байгууллагууд харилцан адилгүй НӨАТ төлж байгаас хамаарч, уг компани НӨАТ төлөгч мөн эсэх талаар холбогдох материалуудыг өгч, зөвлөгөө авахаар төлөвлөн ажиллаж байна.

4. Тусгай зөвшөөрлийн албанаас өр авлага барагдуулах ажлын хүрээнд:

Тусгай зөвшөөрлийн албанаас байгуулсан Ажлын хэсэг нь 2012 оноос хойш үүссэн “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-с шилжиж ирсэн өр, авлагуудыг шүүж төлбөрөө бүрэн төлөөгүй компаниудыг судалж, авлагаа нэхэмжилсний үр дүн нийт 6 компаниас 30,400,000 төгрөгийн авлага барагдуулж ажилласан бөгөөд өр төлбөрөө хүлээн зөвшөөрөөгүй нийт 12 компанийн 95,000,000 төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд улсын тэмдэгтийн хураамж төлж, нэхэмжлэл гарган хэрэг үүсгүүлэн ажилласан боловч шүүхээс хөөн хэлэлцэх хугацаа дууссан, санхүүгийн программ дээр байгаа бичилт нь

шүүхийн нотлох баримтын шаардлага хангахгүй түүнчлэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний төлбөрийг урьдчилан төлбөр авсны үндсэн дээр олгодог гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Мөн тусгай зөвшөөрлийн 29 компанийн 82,900,000 төгрөгийн авлагад гэрээ олдохгүй, шүүхэд хандахад нотлох баримтын шаардлага хангахгүй, шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй, хаяг тодорхойгүй байсантай холбоотой шүүх хүлээж аваагүй тул татан буугдсан болон нэр хаяг тодорхойгүй компаниудыг тодруулахаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт дахин албан тоотоор эрх, үүрэг хаана, ямар байгууллагад шилжсэн байгааг тодруулж өгөхийг хүссэн албан бичиг хүргүүлэн

3.5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ДОТООД СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД

3.5.1. Интернет /шинэчлэл, хамгаалалт/



- Эрчим хүчний үндэсний төвийн байр нь Unitel ХХК-иас цагийн хязгаарлалттай 19 мега байт хурдны хязгаартай, өдрийн цагийн хурдны хязгаар нь 15мб, оройн цагаар нь 4мб-ийн хурдыг өдөр тутам авч хэрэглэж байсан ба 2024 онд интернэтийн хурдыг нэмж 50Mbps буюу цагийн хязгааргүй 50(мегабайт) хурдтай болгон шинэчилсэн. Мөн интернэтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч талаас нэмэлтээр FireWall /FireWare/ WatchGuard T25 загварын хамгаалалтын төхөөрөмжийг 3 жилийн хугацаатай суурилуулт хийгдсэн.
- Эрчим хүчний яам, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-с хамааралтай интернэт сүлжээний шугамын шинэчлэл буюу Шилэн кабель шинээр татах ажил хийгдэж төвийн хэмжээний интернэт сүлжээний хараат бус байдлаас гарсан.
- Сургалт үйлдвэрлэлийн төвийн интернэт сүлжээ үзүүлэгч компани нь удаа дараа дотоод сүлжээний гэмтэл, тасралт зэрэг асуудал гаргаж хэвийн ажиллагаанд саатал учруулсан учир үйлчилгээ үзүүлэгч талыг солих хүсэлтийг ЗУХ-т өгсөний дагуу гүйцэтгэгч талыг өөрчлөн солисон.
 - Unitel ХХК-тай гэрээ байгуулан шилэн кабель шинээр татуулан интернетийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

3.5.2. Сервер /шинэчлэл, засвар/



- Төвийн хэмжээнд сервер шинэчлэл хийгдээгүй олон жил болсонтой холбогдуулан энэ жил серверийн өрөөний тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх ажил хийгдсэн. Үүнд:
 1. Switch: Cisco Catalyst WS-C2960S-48TS-L, 48*GbE, uplink 4*Giga SFP, LAN Base 4 ширхэг
 2. 42unit rack буюу зогсуур өөр дээрээ хөргүүртэй
 3. Patch panel 42 оролттой 4ш
 4. UTP Patch Cord 150ш
 5. Cover cable manager 4ш
 6. PDU 8-outlet All-usage 3ш
 7. UTP CAT5 network cable сүлжээний кабель
 8. Connector: RJ45 холбогч толгой
 9. ASUSTOR LOCKERSTOR 2 Gen2 AS6702T 2-Bay Quad-Core NAS 1ш

Тус тус төхөөрөмжүүдийг шинэчлэн нэмэлтээр суурилуулан ажилласан. Ингэснээр төвийн хэмжээний интернэт, дотоод сүлжээний аюулгүй найдвартай ажиллагаа хангагдаж ажиллах боломж бүрэн бүрдсэн.



- Байгууллагын албаны мэйл хаяг болох info@nec.mn бизмэйл хаягаар ирсэн мэйл хаягуудыг цаг алдалгүй хариуцсан ита-нар өгч ажиллаж байна. Байгууллагаас шаардлагатай үед албаны мэйл хаягаар цахим шуудан хүргүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна байгууллага дээр 14 бизмэйл хаягийг удирдаж цаг тухай бүрт нь найдвартай хэвийн ажиллагааг хангаж удирдан ажиллаж байна. **Үүнд:**


Хүснэгт-5

№	Мэйл нэр	Хэнд
1	davaanyam@nec.mn	Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс Давааням
2	energy_technical@nec.mn	Техникийн нөхцөл
3	enkhbaatar@nec.mn	ЗТХХ Энхбаатар
4	energy_technical@nec.mn	Тусгай зөвшөөрөл
5	finance@nec.mn	Санхүү
6	info@nec.mn	Албаны
7	license@nec.mn	Тусгай зөвшөөрөл
8	misheel@nec.mn	Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс Мишээл

9	printing@nec.mn	Хэвлэх цех
10	purevsuren@nec.mn	Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс Пүрэвсүрэн
11	re@nec.mn	Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс
12	samdan@nec.mn	Сэргээгдэх эрчим хүчний хэлтэс Самдан
13	trainingcenter@nec.mn	Сургалт үйлдвэрлэлийн төв
14	zuwshuurul@nec.mn	Тусгай зөвшөөрөл

- Аблисофт ХХК-тай системийн удирдагч админ эрхтэй ажиллаж байна. Ирсэн, явсан, өргөдөл гомдлыг бүртгэх, цаг ашиглалтын тайлан гаргах, тушаал шийдвэрийн бүртгэл болон гэрээний бүртгэл хүний нөөцийн бааз үүсгэх зэрэг үндсэн үзүүлэлтэй системийг хэвийн ажиллагааг хангаж ашиглаж байна.
- Байгууллагын ИТА-нарын компьютерийн хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах үйднээс Анти вирусны программ 40 ширхэгийг суулгаж байрлуулан ажилласан.
- Мөн байгууллагын вэб хөгжүүлэлт ирэх жилээс зогсох бөгөөд Ерөнхий сайдын 2024 оны 01-р сарын 12-ны өдрийн 01,10 дугаар сарын 02 дугаар албан даалгаврын хэрэгжүүлэх хүрээнд “Нээлттэй мэдээллийн ил тод байршуулахаар заасан мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулах, төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn цахим хуудасны өгөгдлын санг бүрдүүлэх, шинэчлэх ажлыг хийж ажилласан.

Зураг-18 Компанийн цахим хуудас



3.5.3. Суурин утас



Төвийн хэмжээнд 15 дугаар ашиглагддаг бөгөөд үнээс салаалсан гадна дотнын дуудлага хийж хүлээж авдаг 22 дотуур дугаартай суурин утас байна. Нийт 15 дугаарын 22 суурин утас бүгд хэвийн ажиллагаатай байна.

3.5.4. Хурлын заал



- Хурлын заалны тоног төхөөрөмж, ширээ, сандал зэргийг цаг алдалгүй засаж байрлуулан техникийн болон Улсын комиссын хурал гадна дотны онлайн сургалт, хичээл, хэлэлцүүлэг, зөвлөгөөн арга хэмжээнүүдийн үйл ажиллагааны бэлэн байдлын хангаж ажилласан.
- 2024 онд гадны захиалгаар хурлын танхим ашиглах 1 гэрээ хийгдсэн ба нийт гэрээний дүнгээр 3.000.000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Үүнд:

Хүснэгт-6

№	Захиалагч байгууллага	Мөнгөн дүн
1	“Эрчим хүчний манлайлагчид хөтөлбөрийн төгсөгчдийн холбоо” тбб	3.000,000 төгрөг

ДӨРӨВ. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ТАЙЛАН

4.1. ХЭЛТСҮҮДИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

Хүснэгт-7 Хэлтсүүдийн орлогын төлөв байдал

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 он	2024 он		Өөрчлөлт /өссөн+, буурсан-/	
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт орлого	мян/төг	7,582,569.35	11,736,074.62	13,142,718.04	1,406,643.41	11.99
Захиалагч хяналт-Улсын төсвийн хөрөнгө оруулалт	мян/төг	2,363,504.10	2,814,655.90	2,401,931.24	(412,724.66)	(14.66)
Захиалагч хяналт-Хувийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөр	мян/төг	186,429.20	2,563,228.07	2,401,931.24	(161,296.83)	(6.29)
Зураг төсөл магадлалын орлого	мян/төг	656,488.03	600,000.00	722,231.31	122,231.31	20.37
Сэргээгдэх эрчим хүчний орлого	мян/төг	220,720.00	2,878,730.65	1,021,195.18	(1,857,535.48)	(64.53)
Лабораторийн үйл ажиллагааны орлого	мян/төг	485,523.27	580,000.00	542,782.05	(37,217.95)	(6.42)
Тусгай зөвшөөрлийн орлого	мян/төг	1,666,931.92	980,000.00	302,672.29	(677,327.71)	(69.12)
Техникийн нөхцлийн орлого	мян/төг	1,011,148.21	435,000.00	987,187.96	552,187.96	126.94
Сургалтын орлого СҮТ	мян/төг	654,465.06	529,860.00	803,762.27	273,902.27	51.69
Түрээсийн орлого	мян/төг	100,517.73	99,600.00	95,127.27	(4,472.73)	(4.49)
Хүүгийн орлого	мян/төг	112,017.27	90,000.00	273,516.28	183,516.28	203.91
Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	мян/төг	124,824.56	165,000.00	3,590,380.95	3,425,380.95	2,075.99
Нийт зардал	мян/төг	7,248,289.08	11,426,608.45	7,368,512.68	(4,058,095.77)	(35.51)

Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян/төг	334,280.27	309,466.17	5,774,205.35	5,464,739.18	1,765.86
Цэвэр ашиг (алдагдал)	мян/төг	300,852.24	278,519.55	5,224,136.45	4,945,616.89	1,775.68
Нийт авлага	мян/төг	1,118,226.99	1,175,928.54	1,129,292.28	(46,636.25)	(3.97)
Үүнээс: Найдваргүй	мян/төг	416,828.37	416,828.37	416,828.37	-	-
Нийт өр төлбөр	мян/төг	9,847,049.53	4,443,769.51	7,999,760.64	3,555,991.13	80.02
Богино хугацаат өр төлбөр	мян/төг	6,115,939.39	712,659.37	4,268,650.50	3,555,991.13	498.97
Урт хугацаат өр төлбөр	мян/төг	3,731,110.14	3,731,110.14	3,731,110.14	-	-
Нийт ажиллагсдын тоо	хүн	78.00	94.00	80.00	(14.00)	(14.89)
Нийт цалингийн сан	мян/төг	2,573,850.07	4,071,518.10	3,206,543.03	(864,975.08)	(21.24)
Нэг ажилтны дундаж цалин	мян/төг	2,540.50	3,609.50	3,340.10	(269.40)	(7.46)
Борлуулалтын ¹ төгрөгт ногдох зардал	төг	0.96	0.97	0.56	(0.41)	(42.42)
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	мян/төг	555,158.30	2,138,755.30	633,381.62	(1,505,373.68)	(70.39)

График-9 Нийт орлогод эзлэх хувь



Хүснэгт-8 Нийт зардлын талаар дэлгэрэнгүй

№	Зардлын нэр төрөл	Хэмжих нэгж	2023 гүйцэтгэл	2024 он		Өөрчлөлт /өссөн+, буурсан-/	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Ашиглалтын зардал /цахилгаан, халаалт, цэвэр бохир ус/	мян/төг	47,282.73	58,663.25	58,879.11	215.86	0.37

2	Тээвэр, шатахууны зардал	мян/төг	17,202.94	45,655.84	19,437.64	(26,218.20)	(134.88)
3	Харилцаа холбооны зардал	мян/төг	26,184.31	31,359.80	32,792.49	1,432.69	4.37
4	Албан томилолтын зардал	мян/төг	809,816.13	1,054,684.50	989,933.82	(64,750.68)	(6.54)
5	Сургалт семинарын зардал /ИТА/	мян/төг	6,814.12	36,368.50	14,408.19	(21,960.31)	(152.42)
6	Хичээл үйлдвэрлэлийн зардал/ Үнэмлэх сертификат	мян/төг	71,734.29	130,366.63	133,113.66	2,747.03	2.06
7	Цалингийн зардал	мян/төг	2,573,850.07	4,071,518.10	3,206,543.03	(864,975.08)	(26.98)
8	Ажил олгогчоос төлөх НДШ	мян/төг	334,387.43	508,939.76	462,357.83	(46,581.93)	(10.07)
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	мян/төг	127,106.39	153,067.20	152,761.27	(305.93)	(0.20)
10	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал /ХАБ/	мян/төг	80.91	82,764.50	54,995.80	(27,768.70)	(50.49)
11	Албан татвар, төлбөр, даатгал хураамжын зардал	мян/төг	1,444,187.35	1,146,323.16	163,514.82	(982,808.34)	(601.05)
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	мян/төг	406,067.79	530,755.04	554,104.43	23,349.39	4.21
13	Судалгаа хөгжүүлэлтийн зардал	мян/төг	45,000.00	640,000.00	233,381.82	(406,618.18)	(174.23)
14	Харуул хамгаалалтын зардал	мян/төг	26,566.17	39,570.00	32,874.23	(6,695.77)	(20.37)
15	Урсгал зардал, сэлбэг хэрэгсэл	мян/төг	94,660.00	71,347.43	85,667.75	14,320.32	16.72
16	Маркетинг, Зар сурталчилгааны зардал	мян/төг	-	1,200.00	-	(1,200.00)	
17	Ажиллагсдын нийгмийн арга хэмжээний зардал	мян/төг	53,856.61	183,646.00	85,732.14	(97,913.86)	(114.21)
18	Ахмадын зардал	мян/төг	16,710.00	44,812.00	33,916.18	(10,895.82)	(32.13)
19	Хурал зөвлөгөөний зардал	мян/төг	1,682.32	2,950.00	3,613.76	663.76	18.37
20	Конторын хангамжийн зардал	мян/төг	1,662.77	3,600.00	3,319.42	(280.58)	(8.45)
21	Хангамжийн бараа, материалын зардал	мян/төг	59,901.77	108,126.26	105,107.21	(3,019.05)	(2.87)
22	Техникийн нөхцлийн зардал	мян/төг	86,468.25	67,440.00	52,046.50	(15,393.50)	(29.58)
23	Тусгай зөвшөөрлийн зардал /Горимын тооцооны нөхцөл/	мян/төг	-	170,250.00	88,968.00	(81,282.00)	(91.36)
24	Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал	мян/төг	-	2,287.70	-	(2,287.70)	
25	Элэгдлийн зардал	мян/төг	917,724.87	1,293,762.76	528,142.65	(765,620.11)	(144.96)
26	Үйл ажиллагааны бус зардал	мян/төг	36,641.63	250,000.00	234,460.13	(15,539.87)	(6.63)
27	ББӨ /Үндсэн болон туслах эд материал/	мян/төг	42,700.23	61,650.00	38,440.78	(23,209.22)	(60.38)
28	Эрдэнэбүрэн төсөлтэй холбоотой зардал	мян/төг	-	646,000.00	-	(646,000.00)	

Нийт зардал	7,248,289.08	11,437,108.44	7,368,512.68	
-------------	--------------	---------------	--------------	--

